



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 26 өдөр

Дугаар A/175

Эг

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам"-ын 11.10 дахь хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн "2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай" 29 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын 2024 оны A/169 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийг дүгнэлтийг үндэслэн газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтад ялагч болсон 2 (хоёр) малчдын хоршоонд хавсралтад заасан газрыг эзэмшүүлсүгэй.

2. Малчдын хоршоонд эзэмшүүлсэн нэгж талбарыг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэж, газар эзэмших эрхийн эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж, газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээг баталгаажуулыг Газрын даамал (Д.Батчимэг)-д үүрэг болгосугай.

3. Газрыг зориулалтын дагуу ашиглаж, гэрээнд заасан нөхцөл, болзлын хүрээнд газрын төлбөрийг хугацаанд төлөхийг газар эзэмшигч малчдын хоршоо тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232401349